



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589

E-mail: info@macss.gov.mn, http://www.macss.gov.mn

2019.08.13 № 577211

танай _____-ны № _____-г

**Тушаалын хэрэгжилтийг
эрчимжүүлэх тухай**

Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулсан "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн судалгаа", аймаг, дүүрэг бүрээс сонгогдсон цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш нарыг оролцуулан сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлуудыг тодруулах зорилгоор зохион байгуулсан Үндэсний хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Хөтөлбөр батлах тухай" А/494 дүгээр тушаалаар баталлаа.

"Сайжруулсан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй" сургалтыг 2019 оны 08 дугаар сарын 05-09-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулж нийт 120 хүнийг Үндэсний сургагч багшаар бэлтгэлээ.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч, багш, арга зүйч нийт 10081 ажилтнуудад зориулсан Үндэсний сургалтыг 2019 оны 08 дугаар сарын 15-30-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажил хийж байгаа бөгөөд орон нутгийн сургалт 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлнэ.

Сургуулийн өмнөх боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хичээл хөгжүүлэх үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй зохион байгуулах боломжийг хангах, багшийн ажлыг хүүхэд бүрийг хөгжүүлэх, тэдний хөгжилд ахиц гаргахад чиглүүлэх, сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдрын онцлог, ачаалал даах чадвараас давсан, тэдний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөхүйц төрөл бүрийн уралдаан, тэмцээнийг цэцэрлэгүүдийн хооронд болон цэцэрлэгийн хүүхдийг оролцуулан зохион байгуулахгүй байх зорилгоор БСШУС-ын сайдын 2019 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/192 дүгээр тушаалыг батлан хэрэгжүүлж байгаа билээ.

Тушаалын 2 дахь заалтад "Тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, ахмад үе, уламжлалаа хүндэтгэх, байгаль орчноо хайрлан хамгаалах, хүнлэг тусч чанар, харилцааны соёлтой болгох, хүүхдийн бие бялдрын хөгжлийг хангахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа, багийн уралдаан, тэмцээн зохион байгуулахыг дэмжих"–ээр тусгагдсан.


My doc/ alban blank A4

09 09513

Иймд аймаг, нийслэлийн түвшинд цэцэрлэгийн хүүхдийн дунд зохион байгуулах уралдаан, тэмцээнийг цөөлөх, ач холбогдолгүй олон уралдаан, ашгийн төлөө зарим үйл ажиллагааг зогсоож, хичээлийн жилд 2-оос илүүгүй байхаар тооцож нэгдсэн төлөвлөгөөнд оруулан, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг хүсье.

Түүнчлэн цэцэрлэгийн багш нарыг хүүхэдтэй ажиллах цаг, боломжийг бүрдүүлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүрэгт хамааралгүй арга хэмжээнд дайчлан оролцуулахгүй байхад анхаарч уг тушаалыг хэрэгжүүлж ажиллана уу.

Хавсралт 2 хуудастай

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.МЯГМАР



УХАБ149

5110621



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/192

Улаанбаатар хот

Сургалтын үйл ажиллагааны зохион
байгуулалтыг сайжруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.8, 28.1.15, 44 дүгээр зүйлийн 44.1.1, 45 дугаар зүйлийн 45.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" улсын 2 дугаар зөвлөгөөний зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Сургалтын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, багшийн ажлыг хүүхэд бүрийг хөгжүүлэх, сургалтын чанарт ахиц гаргахад чиглүүлэх, суралцагчдын суралцах нөхцөл бололцоог сайжруулах зорилгоор дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн эрхлэгч, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

1.1. Бага ангид хүүхдийг эрэмбэлж ялгаа үүсгэсэн, суралцах хүсэл эрмэлзлэлийг бууруулсан, сургалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан олимпиад, уралдаан, тэмцээн зохион байгуулахгүй байх;

1.2. Тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх, ахмад үе, уламжлалаа хүндэтгэх, байгаль орчноо хайрлан хамгаалах, хүнлэг тусч зан чанар, харилцааны соёлтой болгох, бие бялдрын хөгжлийг хангахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа, багийн уралдаан, тэмцээн зохион байгуулахыг дэмжих;

1.3. Улсын шалгалтад чанартай бэлтгэх нөхцөлийг хангах зорилгоор 2018-2019 оны хичээлийн жилд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн 9, 12 дугаар ангийн суралцагч, холбогдох багш нарыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас баталсан олон улсын болон дотоодын төрөлжсөн олимпиад, Монголын хүүхдийн спортын YI наадмын зуны төрлийн анхан шатны тэмцээнээс бусад уралдаан, тэмцээнд тус тус зохион байгуулалттай оролцуулахгүй байх;

1.4. Цаашид аливаа олимпиад, уралдаан тэмцээнийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас батлах журамд нийцүүлэн зохион байгуулах;

1.5. Хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулах, сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй аливаа үйл ажиллагаанд багш нарыг оролцуулахыг хязгаарлаж, үүнээс шалтгаалсан нэмэлт ачаалал үүсгэхгүй байх;

130584

1.6. Энэ тушаалын 1.2-т заасан уралдаан, тэмцээн зохион байгуулахад суралцагчаас хураамж авахыг хориглох;

2. Аймаг, нийслэлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг дэмжих, багш, суралцагчийг хуульд заасан сургах, суралцах нөхцөл боломжоор хангах, сургалтын бус үйл ажиллагаанд зохион байгуулалттайгаар оролцуулахгүй байх талаар холбогдох шийдвэрүүдийг гаргаж, энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлагаар ханган ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт зөвлөсүгэй.

3. Тушаалыг хэрэгжүүлэн, бодит үр дүн, чанарын өөрчлөлт гаргахад хяналт тавьж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Г.Дуламжав/, Ерөнхий боловсролын бодлогын газар /Л.Ням-Очир/-т тус тус даалгасугай.

САЙД

A handwritten signature in black ink is written over a rectangular official stamp. The signature is stylized and appears to be 'E. Baatarbilэг'. The stamp contains some faint, illegible text and a date.

Ё.БААТАРБИЛЭГ